# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын
төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын
дэд тайлан: Засгийн газраас олгосон векселийн үр дүн

## ТӨСВИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ВЕКСЕЛИЙН ХҮҮГИЙН ТӨЛБӨРТ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАГДАЖ БАЙНА

**Улаанбаатар**
**2017 он**

## АГУУЛГА

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
М.Давааням

Хөрөнгө оруулалтын албаны менежер:
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор:
Б.Саруул

Аудиторууд:
Б.Анхбаатар
Б.Лхагвацэрэн
Б.Хишигтогтох
Б.Хаш-Эрдэнэ
Д.Эрдэнэцогт
М.Туул

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын аудитор, шинжээчид оролцов.

2017 оны 6 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755 дугаарын утсаар харилцана уу.

***Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.***

www.audit.mn


Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл ..... 1
Аудитад ашигласан шалгуур ..... 1
Товчилсон үгийн тайлбар ..... 2
Хүснэгтэн мэдээллийн агуулга ..... 2
Ерөнхий мэдээлэл ..... 3

**Бүлэг 1. Улсын Их Хурлаас зөвшөөрөл олгогдоогүй байхад вексель бичиж Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна**

- *УИХ-аас холбогдох шийдвэр, зөвшөөрөл гараагүй байхад төсвийн зарлагад тусгагдах векселийн үндсэн болон хүүгийн төлбөрийн зардлыг Засгийн газар, Сангийн яам шийдвэрлэж ирсэн нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна* ..... 7

**Бүлэг 2. Төсвийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс векселийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагджээ**

- *Векселиэр санхүүжсэн төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл УИХ-ын тогтоолоор заасан хэмжээнд хүрээгүй байна* ..... 8
- *Векселиэр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдох зарим хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна* ..... 8
- *Векселийн санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын дансаар дамжуулахгүй гүйцэтгэгч байгууллагад шууд олгож ирсэн нь төлбөр, тооцооны зөрүү үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ* ..... 9
- *Засгийн газар нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийг зөрчсөн шийдвэр гаргасан нь төсвийн үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна* ..... 10
- *Төсвийн орлогыг бодитой төлөвлөдөггүйгээс векселийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна* ..... 11

**Бүлэг 3. Векселиэр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн чанар, ашиглалт хангалтгүй байна**

- *Захиалагчийн хяналт хангалтгүй, гүйцэтгэгч байгууллага хариуцлагагүй ажилласнаас зарим барилга, байгууламжийн гүйцэтгэлийн чанар, ашиглалт хангалтгүй байна* ..... 12

**Дүгнэлт**: ..... 14

**Зөвлөмж:** ..... 15

**Сангийн яамнаас ирүүлсэн санал:** ..... 16

**Саналд өгсөн тайлбар**: ..... 19

**Хавсралт:** ..... 20

| | |
|---|---|
| | **Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл** |
| **Аудит хийх үндэслэл:** | Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв. |
| **Аудитын зорилт:** | Засгийн газраас векселиэр санхүүжилт олгосон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. |
| **Хамрах хүрээ:** | Аудитыг гүйцэтгэхдээ Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт Үндэсний аудитын газраас хийж байгаа нэгдсэн удирдамжтай аудитын хүрээнд 2015-2016 онд векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгайлан авч үзсэн ба аудитад тэдгээр төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг Төсвийн ерөнхийлөн захирагчид болон аймаг, нийслэл дэх холбогдох байгууллагууд, төсөл гүйцэтгэгч зарим ААН-ийг хамруулав. |
| **Аудитын арга зүй:** | Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. |
| **Аудитад ашигласан шалгуур:** | Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.<br>▪ Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулиуд болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд;<br>▪ Төсвийн тухай хууль;<br>▪ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;<br>▪ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль;<br>▪ Авто замын тухай хууль;<br>▪ Барилгын тухай хууль;<br>▪ Иргэний хууль;<br>▪ Векселийн тухай хууль;<br>▪ Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд;<br>▪ Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”;<br>▪ Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”. |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **ААН** | Аж ахуйн нэгж |
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| **БСШУСЯ** | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **УИХ** | Улсын Их Хурал |
| **ТБОНӨХБАҮХАТХ** | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| **ТӨХК** | Төрийн өмчит хувьцаат компани |
| **ХХК** | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА

| | | |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Хуудас 7 | Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн хэрэгслээр /тэрбум төгрөгөөр/ |
| Хүснэгт 2 | Хуудас 11 | Улсын төсвийн орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/ |

## Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлаар 1995 онд Векселийн тухай хууль батлагдсанаар иргэн, хуулийн этгээдийн хооронд хийгдэх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдсон харилцаа зохицуулагдаж иржээ.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 153/180 дугаар тушаалаар “Векселийг төлбөр тооцоонд хэрэглэх журам”-ыг баталж, мөрдүүлж байна.

Дээрх хууль, тогтоомжид зааснаар вексель нь сарын, эсхүл жилийн хүүтэй, 1 хүртэл жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдийн хооронд авлага, өглөгтэй байгаа болон бусад тохиолдолд бичигдэх ба векселийн төлбөрийг хэсэгчлэн хийхийг хориглодог байна.

Монгол Улсын 2008-2015 оны төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдэд тухайн төсвийн жилд санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс үүссэн өр, төлбөрийг векселиэр баталгаажуулах замаар шийдвэрлэсэн байна.

Засгийн газраас 2015-2016 онд гаргасан векселийн хүүг Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн хүүгийн түвшинг үндэслэн тогтоож ирсэн бөгөөд дээрх хугацаанд 697.2 тэрбум төгрөгийн вексель бичигдэж векселийн үндсэн төлбөрт 697.2 тэрбум, хүүгийн төлбөрт 69.7 тэрбум нийт 767.0 тэрбум төгрөгийг[1] 2016-2017 онд төлж барагдуулжээ.

Векселиэр төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

а. УИХ-ын 2015 оны 7-р тогтоолд:

- Монгол Улсын төсвийн 2008-2014 онуудын хөрөнгө оруулалтад тусган бүрэн хэрэгжүүлж дууссан, гэрээний үлдэгдэл санхүүжилт бүхий 96 төсөл, арга хэмжээнд 32.9 тэрбум төгрөгийн вексель бичихээр,
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан, бодит гүйцэтгэл нь 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 80-аас дээш хувьтай хэрэгжиж буй төслүүдийг,

б. УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолд:

- Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан, урьдчилсан гүйцэтгэл нь 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 80 хувиас дээш гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж байгаа боловч санхүүжилтийг нь бүрэн олгож чадаагүй төсөл, арга хэмжээний болон 2015 онд "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр ажил нь бүрэн дууссан төслийн санхүүжилтийг тус тус векселиэр санхүүжүүлэх арга хэмжээг авч, төлбөрийг Монгол Улсын 2016, 2017 оны төсвийн төсөлд тусгахыг Засгийн газарт даалгажээ.

[1]Холбогдох мэдээлэлтэй Хавсралт 1-ээс танилцана уу.

Засгийн газрын 2015 оны 105 дугаар тогтоолд:

УИХ-ын 2015 оны 7 дугаар тогтоолын дагуу тус тогтоолыг гаргахдаа 2014 онд бэлтгэгдсэн нөөцийн махны урамшууллын үлдэгдэл 4.5 тэрбум төгрөгийн дутуу санхүүжилтийн бодит гүйцэтгэлийг хянаж, векселиэр баталгаажуулахыг Сангийн яаманд үүрэг болгосон байна.

Сангийн яамнаас “Эрдмийт” ХХК-д 0.3 тэрбум, "Дархан меат фүүдс" ХХК-д 0.3 тэрбум, "Баатарууд тэнгэр" ХХК-д 1.9 тэрбум, "Эй Эн Ди Эм" ХХК-д 1.9 тэрбум нийт 4.5 тэрбум төгрөгийн векселийг тус тус бичиж, төлбөрийг “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд 2016 оны 01 дүгээр сарын 06-нд Монголбанкнаас санхүүжүүлжээ.

Засгийн газрын 2015 оны 282, 388 дугаар тогтоолд:

УИХ-ын 2015 оны 7 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 282 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байсан 143.2 тэрбум төгрөгийн 235 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг векселиэр баталгаажуулах шийдвэр гарсан. 2015 оны 9 дүгээр сард тус тогтоолд Засгийн газрын 388 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, векселиэр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тоо 237, санхүүжих дүн 184.4 тэрбум төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Сангийн яамнаас вексель бичихдээ дээрх тогтоолд тусгагдсан векселиэр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний дүнг дахин хянаж, нийт 159.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 331 ААН-д олгожээ.

Векселиэр санхүүжүүлтийг нь олгож 2015 онд Засгийн газрын өрд бүртгэгдсэн векселийн үндсэн төлбөр 159.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөр 12.2 тэрбум төгрөгийг Монгол улсын 2016 оны төсөвт тусгаж, арилжааны банкуудад төлж барагдуулсан байна.

Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолд:

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Энержи Ресурс” ХХК-ийн хэрэгжүүлж байсан “Ухаа худаг-Гашуунсухайт” чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төслийг “Монголын төмөр зам” ТӨХК-нд шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2013 оны 05 дугаар сарын 06-нд төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, шилжүүлэх концессын гэрээг цуцлах гэрээ байгуулжээ.

2013 оны 7 дугаар сард тус төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан хөрөнгө, баримт материалыг хүлээлцсэн акт үйлдэгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтад тооцож хувьцаанд хөрвүүлэх эсхүл буцаан олгох дүнг 84.3 тэрбум төгрөг болохыг харилцан тохиролцсон байна.

Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 478 дугаар тогтоолоор тус төлбөр болон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн бондын хүүг Хөгжлийн банкны санхүүжилтээр шийдвэрлэх хүртэл хугацаанд векселиэр баталгаажуулах шийдвэр гарсан.

Тус тогтоолын дагуу гарсан Сангийн сайдын 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 22 дугаар болон 2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 141 дүгээр тушаалыг үндэслэн дээрх төлбөрт 15.2 хувийн хүүтэй, 119.5 тэрбум төгрөгийн вексель бичигдэж,

2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр үндсэн төлбөрт 119.5 тэрбум, хүүгийн төлбөрт 18.2 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад төлсөн байна.

Засгийн газрын 2016 оны 72, 117, 239, 257 дугаар тогтоолуудад:

УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын 2016 оны 72 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байсан 161, концессээр хэрэгжүүлж байсан 2, нийт 163 төсөл, арга хэмжээнд 87.8 тэрбум төгрөгийг векселиэр санхүүжүүлэх шийдвэр гаргажээ.

Засгийн газрын 2016 оны 117, 239, 257 дугаар тогтоолуудаар тус тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, төсөл арга хэмжээний тоог 197, векселиэр санхүүжүүлэх дүнг 161.9 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Тэдгээрээс 124.8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр давхардсан тоогоор 268 ААН-д Сангийн яамнаас вексель бичсэн бөгөөд холбогдох төлбөрийг Монгол улсын 2016 оны төсөвт тодотголоор тусгаж, векселийн үндсэн төлбөр 124.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 10.6 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад төлж барагдуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 77 дугаар тогтоолд:

УИХ-ын холбогдох шийдвэргүйгээр, Засгийн газрын 2016 оны 77 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замын “барих-шилжүүлэх” концессийн гэрээний эхний жилийн 80 хувийн төлбөр буюу 183.6 тэрбум төгрөгийн төлбөрийг векселиэр баталгаажуулах шийдвэр гарсан.

Үүний дагуу 2016 оны 2 дугаар сарын 26-нд 183.6 тэрбум төгрөгийн вексель бичигдэж санхүүжилт олгосон бөгөөд 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдөр үндсэн төлбөрт 183.6 тэрбум, хүүгийн төлбөрт 27.3 тэрбум төгрөгийг арилжааны банкинд төлсөн байна.

Засгийн газрын 2016 оны 195 дугаар тогтоолд:

УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын 2016 оны 195 дугаар тогтоолоор Ховдын Булган-Үенч-Ховдын чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын 4.1 тэрбум төгрөгийн төлбөрийг векселиэр баталгаажуулах тухай шийдвэр гарсны дагуу векселийг 2016 оны 7 дугаар сард бичиж, 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр үндсэн төлбөрт 4.1 тэрбум, хүүгийн төлбөрт 0.5 тэрбум төгрөг арилжааны банкинд төлсөн байна.

Засгийн газрын 2016 оны 284 дүгээр тогтоолд:

УИХ-ын холбогдох шийдвэр, зөвшөөрөлгүйгээр Засгийн газрын 2016 оны 284 дүгээр тогтоолоор “Ухаахудаг-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг барихад оруулсан хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн бондын 2013-2016 онд хуримтлагдсан хүүгийн 31.9 тэрбум төгрөгийн төлбөрийг векселиэр баталгаажуулах шийдвэр гарсны дагуу 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр вексель бичиж 2016 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр төлж барагдуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолд:

УИХ-ын холбогдох шийдвэр, зөвшөөрөлгүйгээр Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилгоор “Бэрэн” ХХК-

иас 223 айлын орон сууцыг худалдан авах, худалдан авсан орон сууцны үнэ болох 15.0 тэрбум төгрөгийн төлбөрийг 2017 оны улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэхийг холбогдох сайдуудад даалгахдаа төлбөрийг векселиэр баталгаажуулахыг Сангийн сайдад зөвшөөрчээ.

Үүний дагуу 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр 15.0 тэрбум төгрөгийн вексель бичсэн бөгөөд тус төлбөрийг Монгол улсын 2016 оны төсөвт тодотголоор тусгаж, 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр үндсэн төлбөрт 15.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 0.9 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад төлж барагдуулсан байна.

<u>Сангийн сайдын 2016 оны 38 дугаар тушаалд:</u>

Сангийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 2016 оны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2015 онд урьдчилан төлүүлсэнтэй холбоотойгоор үүссэн 54.0 тэрбум төгрөгийн өрийг баталгаажуулж, тус компанид хүүгүй, 90 хоногийн хугацаатай, сунгах боломжтой нөхцөл бүхий векселийг гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх шийдвэр гарсан.

Үүний дагуу Сангийн яам 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдөр тус компанитай гэрээ байгуулж, төлбөрийг тус компанийн 2016 онд төлөх АМНАТ, НӨАТ-ын төлбөрөөс суутган тооцож, барагдуулсан байна.

**БҮЛЭГ 1**

## Улсын Их Хурлаас зөвшөөрөл олгогдоогүй байхад вексель бичиж Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна

### УИХ-аас холбогдох шийдвэр, зөвшөөрөл гараагүй байхад векселийн үндсэн болон хүүгийн төлбөрийн зардлыг Засгийн газар, Сангийн яам шийдвэрлэж ирсэн нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна

1.1 Засгийн газар, Сангийн яам векселиэр санхүүжилт олгох, векселийн үндсэн болон хүүгийн зардлыг төсөвт тусгахтай холбоотой шийдвэрийг удаа дараа гаргахдаа төсвийн талаарх УИХ-ын бүрэн эрхийг [2] зөрчиж, хуульд заагаагүй эрх, үүргийг хэрэгжүүлж ирсэн байна. *Тухайлбал,*

- *Засгийн газрын 2016 оны 77, 284, 298 дугаар тогтоолууд нь УИХ-ын холбогдох шийдвэргүйгээр гарч, нийт 230.5 тэрбум төгрөгийн төлбөрийг 2016 оны 1-6 дугаар сард векселиэр санхүүжүүлсэн байна.*
- *2016 оны 9 дүгээр сард УИХ-аар баталсан Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралтад улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэх 411 төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлахад зохих шийдвэр, зөвшөөрөлгүйгээр бичигдсэн дээрх векселийн санхүүжилтийг нөхөн хамруулжээ.*

1.2 Тус жагсаалтаар нийт 411 арга хэмжээг 672.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэл нь 659.5 тэрбум төгрөг буюу 98 хувь байна.

1.3 Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан нийт 411 төсөл, арга хэмжээнээс вексель бичигдээгүй байсан 53 арга хэмжээний 25.3 тэрбум төгрөгийг гүйцэтгэгчид улсын төсвөөс шууд санхүүжүүлж, вексель бичигдсэн 358 арга хэмжээний 634.2 тэрбум төгрөгийг 2016-2017 онд арилжааны банкуудад төлж барагдуулсан байна.

1.4 2016 онд векселийн хүүд төлсөн зардал 23.7 тэрбум төгрөг буюу улсын төсвийн нийт хүүгийн зарлагад 2.6 хувийг эзэлж байна[3].

1.5 Засгийн газраас олгосон векселийн төлбөрийг 2017 оны 5 дугаар сарын 10-ны байдлаар бүрэн төлж, векселиэрх өрийн үлдэгдэлгүй болсон байна.

*Хүснэгт 1.* Засгийн газрын дотоод өрийн бүтэц, өрийн хэрэгслээр */тэрбум төгрөг/*

| | Дотоод өрийн бүтэц | 2015.12.31 | 2016.03.31 | 2016.06.30 | 2016.09.30 | 2016.12.31 | Эзлэх хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үнэт цаас | 3,333.2 | 3,345.1 | 3,145.0 | 3,567.6 | 5,488.8 | 84.9% |
| 2. | Зээл | | 200.0 | | | | |
| 3. | Вексель | 164.3 | 589.3 | 600.0 | 443.3 | 307.2 | 4.8% |
| 4. | Концесс | 261.0 | 237.1 | 319.0 | 590.4 | 668.9 | 10.3% |
| 5. | Татварын урьдчилгаа | 41.4 | | | | | - |
| **Засгийн газрын дотоод өр** | | **3,800.0** | **4,371.5** | **4,063.9** | **4,601.3** | **6,464.9** | **100%** |
| ЗГ-ын вексель/ЗГ-ын дотоод өр | | **4.3%** | **13.5%** | **14.8%** | **9.6%** | **4.8%** | |
| ЗГ-ын вексель/ЗГ-ын нийт өр | | **1.1%** | **3.7%** | **3.6%** | **2.3%** | **1.4%** | |
| ЗГ-ын вексель/ДНБ | | **0.7%** | **2.4%** | **2.5%** | **1.8%** | **1.3%** | |
| ЗГ-ын нийт өр | | 14,427.4 | 15,928.9 | 16,612.5 | 19,355.0 | 22,280.1 | |
| ДНБ (оны үнээр)-Урьд.гүйц | | 23,134.1 | 24,203.5 | 24,203.5 | 24,203.5 | 23,886.4 | |

*Эх сурвалж: Сангийн яам*

[2] 9.1.2.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв, тэдгээрийн тодотголыг хэлэлцэж, батлах

[3] Жич: Монгол улсын 2016 оны төсвийн нийт хүүгийн зардал урьдчилсан гүйцэтгэлээр 926.3 тэрбум төгрөг

**БҮЛЭГ 2**

## Төсвийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс векселийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагджээ

### Векселиэр санхүүжсэн төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл УИХ-ын тогтоолоор заасан хэмжээнд хүрээгүй байна

2.1 Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл 80-аас доош хувьтай байхад векселиэр санхүүжилт олгох тухай Засгийн газрын тогтоолд 80-аас дээш хувьтай гэж баталсан тохиолдол цөөнгүй байна. *Тухайлбал,*

- *Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Баян-Өлгий, Сагсай сум/ - 980.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 20 хувь;*
- *Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Завханмандал сум/ - 1,420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 30 хувь;*
- *Сургуулийн барилга, 640 суудал /Булган, Булган сум, 1 дүгээр сургууль/ - 4,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 30 хувь;*
- *Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/ - 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 27 хувь;*
- *Сургуулийн барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум/ - 5,426.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 39.6 хувь;*
- *Ахмадын сувиллын газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ - 710.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 73 хувь;*
- *Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/ - 786.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын явц 40 хувь.*

### Векселиэр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдох зарим хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна

2.2 Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад тендерийн хэмнэлт, магадлашгүй ажлын хэмнэлт зэрэг шалтгаануудаас санхүүжилт олгох боломжгүй 2,226.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 25 төсөл, арга хэмжээ батлагдсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2[4], 5.1.5[5] дахь заалтууд зөрчигдөж тооцоолол, судалгаа хангалтгүй хийгдсэнийг харуулж байна.

2.3 “Түрээсийн орон сууц” хөтөлбөр нь байр сууцгүй иргэдийг түрээсийн орон сууцаар хангах, нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой хөтөлбөр хэдий ч Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолоор тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон сууц худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй, үнийн судалгаа, харьцуулалт хийгээгүй, төлбөрийг вексель бичихгүй, хүүгийн зардал үүсгэхгүйгээр гүйцэтгэх боломжийг эрэлхийлээгүй байна. *Тухайлбал,*

- *2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр 14.9 тэрбум төгрөгийн вексель бичиж “Бэрэн” ХХК-иас 1 мкв-ыг нь 1,880.0 мянган төгрөгөөр 223 айлын орон сууцыг шууд худалдан авсан бөгөөд тус төлбөрийг Монгол улсын 2016 оны төсөвт тодотголоор тусгаж, 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр үндсэн төлбөрт 14.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 0.9 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад төлж барагдуулсан байна.*

[4] төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;
[5] ил тод байдлыг хангасан байх;

2.4 2015 онд вексель бичиж санхүүжүүлсэн дараах төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хэмнэлтийг зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.26[6] дахь заалтыг зөрчсөн байна. *Тухайлбал,*

- *"Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах" ажлын төсвийн хэмнэлт 500.5 сая төгрөг;*
- *"Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамын өргөтгөл, шинэчлэлт" ажлын төсвийн хэмнэлт 339.9 сая төгрөг.*

2.5 Эрчим хүчний сайдын төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах 2015 онд вексель бичиж санхүүжүүлсэн дараах 11.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээний төсөвт магадлашгүй ажлын зардлын 2 хувийг тусгаагүй нь Барилгын төсөв зохиох дүрмийн 10.4[7] дэх заалтыг зөрчсөн байна. *Тухайлбал,*

- *Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 35 кВ-ын 135 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Баянхонгор/;*
- *5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй сумдын 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын иж бүрэн шинэчлэл /Улсын хэмжээнд/;*
- *0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дулааны цахилгаан станц 2-ын ПТ-12-35 турбины тохируулгын блок сольж шинэчлэх /Улаанбаатар/;*
- *0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дулааны цахилгаан станцын 12 МВт-ын турбины тохируулгын блок, тулах холхивчийн шинэчлэл /Дархан Уул, Дархан сум/;*
- *0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторыг шинээр байгуулах /Улаанбаатар/;*
- *0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Багуудын цахилгаан хангамжийг сайжруулах /Дорнод, Хэрлэн сум, 1,8 дугаар баг/.*

## Векселийн санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын дансаар дамжуулахгүй гүйцэтгэгч байгууллагад шууд олгож ирсэн нь төлбөр, тооцооны зөрүү үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ

2.6 Магадлашгүй ажлын акт, холбогдох баримтын бүрдэл дутуу байхад дараах 8 төсөл, арга хэмжээнд векселиэр нийт 52.1 сая төгрөгийг олгожээ.

- *Аймгийн төвд шинээр баригдаж байгаа орон сууцны барилгуудын гадна инженерийн шугам сүлжээний ажил /Архангай, Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээний 2.6 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *"Цэрэг спортын төв цогцолбор" төсөл /Алдар спорт хороо/ /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл, арга хэмжээний 10.9 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *"Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх" төсөл, арга хэмжээний 14.6 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *Говийн бүсийн сургалтын төв /Өмнөговь, Даланзадгад сум/ төсөл, арга хэмжээний 6.2 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *Халдвартын эмнэлгийн барилга, 30 ор /Завхан, Улиастай сум/ төсөл, арга хэмжээний 4.4 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /Өвөрхангай, Арвайхээр сум/ төсөл, арга хэмжээний 1.7 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *"Хайстайн лаврингийн гол ордны сэргээн засварлалт" төсөл, арга хэмжээний 8.2 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*
- *Завхан аймгийн Асгат сумын хичээлийн байрны халаалтын засварын ажлын 3.5 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардал;*

[6] Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын үр дүнд бий болсон хэмнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч ашиглахгүй
[7] Тухайн зураг төслийн объект бүрийн "барилга угсралтын ажил", "тоног төхөөрөмж," "бусад зардал", "Бүгд" гэсэн ангилалаар төсөвт өртгийг тодорхойлж нэгдсэн төсвийн тооцоонд тусгана. Барилгын өртгийн нэгдсэн төсвийн тооцооны "бусад ажил" гэсэн бүлэгт тусад нь төсөв зохиож барилга угсралтын ажлын төсөвт өртөгт шингээдэг энэ дүрмийн 9.1-д заагдсан зардлууд, "захиалагчийн хяналтын зардал", "магадлашгүй ажлын зардал", "нэмэгдсэн өртгийн албан татвар", "зураг төсөл-хайгуулын ажлын зардал" "нормчлолын сангийн шимтгэл" зэрэгт гарах хөрөнгийн хэмжээг тусгана.

2.7 Аудитаар дараах төсөл, арга хэмжээнд векселиэр санхүүжилт олгохдоо гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүнгээс илүү төлбөр шилжүүлсэн зөрчлийг илрүүлж, нийт 67.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов. *Тухайлбал,*

- *Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Завхан, Улиастай сум, 3 дугаар сургууль/ - гүйцэтгэгч "Зуурмаг" ХХК-д олгосон 19.4 сая төгрөгийн илүү санхүүжилт;*
- *Завхан аймгийн Улиастай сумын 30 ортой Халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажил - гүйцэтгэгч "Зуурмаг" ХХК-д олгосон 20.1 сая төгрөгийн илүү санхүүжилт;*
- *Сургуулийн барилгын өргөтгөл, 520 суудал /Увс, Улаангом сум, Шинэ-Ирээдүй/ - гүйцэтгэгч "Мөнхжим өргөө" ХХК-д олгосон 21.1 сая төгрөгийн илүү санхүүжилт;*
- *Спорт цогцолборын барилга /Ховд, Манхан сум/ - гүйцэтгэгч "Жаргалант луу" ХХК-д олгосон 7.3 сая төгрөгийн илүү санхүүжилт.*

2.8 Эрчим хүчний сайдын төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах векселээр санхүүжигдсэн 4 төсөл, арга хэмжээний техник хяналтын зардлын үлдэгдэл 14.2 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад олгосон нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын 3 дугаар зүйлийн 3.19[8] гэсэн заалтыг зөрчсөн байна. *Тухайлбал,*

- *ДЦС-2-ийн зуухны шинэчлэл /Улаанбаатар/-ийн ажлын зарцуулагдаагүй техник хяналтын зардал 0.5 сая;*
- *Дулааны цахилгаан станц 2-ын ПТ-12-35 турбины тохируулгын блок сольж шинэчлэх /Улаанбаатар/ ажлын зарцуулагдаагүй техник хяналтын зардал 2.9 сая;*
- *Дулааны цахилгаан станцын 12 МВт-ын турбины тохируулгын блок, тулах холхивч шинэчлэл /Дархан Уул, Дархан/-ийн ажлын зарцуулагдаагүй техник хяналтын зардал 9.8 сая;*
- *Дулааны станцын К1, К2 зуухны засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Шарын гол/-ийн ажлын зарцуулагдаагүй техник хяналтын зардал 1.1 сая.*

## Засгийн газар нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийг зөрчсөн шийдвэр гаргасан нь төсвийн үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна

2.9 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмжийн 1[9]-д заасныг зөрчиж 2012 оны 5 дугаар сарын 31-ны өдөр Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, "Энержи Ресурс" ХХК-тай "Ухаахудаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц "барих-ашиглах-шилжүүлэх" концессын гэрээг байгуулжээ.

2.10 Дээрх шийдвэрийг залруулж, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор "Энержи Ресурс" ХХК-тай байгуулсан концессын гэрээг цуцалж, "Монголын төмөр зам" ТӨХК-тай тус концессын зүйлийг гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах шалтгаан болсон байна. Тухайлбал:

- *Концессын гэрээг цуцалсаны дагуу 2013 оны 7 дугаар сард Төрийн өмчийн хорооны ажлын хэсэг тус төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан хөрөнгө, баримт материалыг хүлээлцэн хөрөнгө оруулалтад тооцож хувьцаанд хөрвүүлэх, эсхүл буцаан олгох дүнг 84.3 тэрбум төгрөг болохыг харилцан тохиролцож акт үйлдсэн байна.*
- *Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 478 дугаар тогтоолоор тус төлбөрийг векселиэр баталгаажуулах шийдвэр гарсан. Үүний дагуу "Энержи Ресурс" ХХК 84.3 тэрбум төгрөгийн төлбөрийг тухайн үеийн ханшаар тооцон 59.8 сая ам.долларыг Сангийн яамнаас нэхэмжилсэн байна.*

[8] Захиалагч барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ

[9] Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд Концессын тухай хуулийн 17.1.1-д заасан журмын дагуу олгох

- *Нэхэмжилсэн төлбөрийг төгрөгөөр төлөхөөр 59.8 сая ам.долларыг вексель бичигдсэн өдрийн ханшаар тооцоход 119.5 тэрбум төгрөг болж ам.долларын ханшийн зөрүүнээс шалтгаалан 35.8 тэрбум төгрөгийг нэмж төлөхөөр вексель бичигдсэн байна.*
- *Векселиэр баталгаажуулсан 119.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрт 18.2 тэрбум төгрөгийн үр ашиггүй зардал гарсан байна.*
- *Тус төслийг хэрэгжүүлэхэд "Энержи Ресурс" ХХК-ний гадны зах зээл дээр гаргасан бондын 2013-2016 онд хуримтлагдсан хүүгийн төлбөрт 31.9 тэрбум төгрөгийн зардал гарсан байна.*

## Төсвийн орлогыг бодитой төлөвлөдөггүйгээс векселийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна

2.11 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн орлоготой уялдуулан төлөвлөж ирээгүйгээс векселийн үндсэн болон хүүгийн төлбөрийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж иржээ. *Тухайлбал,*

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон концессийн төлбөртэй холбоотой Засгийн газрын векселиэр санхүүжилт олгох тухай 2015 болон 2016 онуудад гарсан тогтоолуудын дагуу үндсэн төлбөрт 697.2 тэрбум, хүүгийн төлбөрт 69.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс 2016 - 2017 онд төлсөн байна.*

*Хүснэгт 2. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл* */тэрбум төгрөг/*

| Төсвийн орлого | 2013 он | 2014 он | 2015 он |
|---|---|---|---|
| Орлогын төлөвлөгөө | 4,606.4 | 4,770.1 | 4,032.1 |
| Орлогын гүйцэтгэл | 4,057.3 | 4,244.3 | 3,834.0 |
| Орлогын тасалдал | 549.2 | 525.8 | 198.1 |

*Эх сурвалж: Сангийн яам*

2.12 Векселиэр төлбөрийг гүйцэтгэснээр хүүгийн төлбөрт нэмэлт зардал гарсан хэдий ч 415 аж ахуй нэгжид он дамжиж хуримтлагдсан 697.2 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг барагдуулсан нь эдгээр аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зохих үр дүнд хүрсэн байна.

## БҮЛЭГ 3 Векселиэр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн чанар, ашиглалт хангалтгүй байна

**Захиалагчийн хяналт хангалтгүй, гүйцэтгэгч байгууллага хариуцлагагүй ажилласнаас зарим барилга, байгууламжийн гүйцэтгэлийн чанар, ашиглалт хангалтгүй байна**

3.1 Гүйцэтгэгч компанийн чанаргүй, дутуу хийсэн ажлыг "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу байгуулагдсан комисс 100 хувь гүйцэтгэсэн гэж байнгын ашиглалтад хүлээн авсан тохиолдол гарсан байна. *Тухайлбал,*

- *Сургуулийн спорт заалны барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ - Цэвэр ус шахах насос хүлээлгэж өгөөгүйн улмаас бие засах газар, усанд орох өрөө ашиглагдаагүй, гадна зам талбайн ажлаас явган замыг өнгөт хавтангаар хийх 604.2 м2 талбайг хийгээгүй, батлагдсан зургаар заалны гэрэлтүүлгийг таазанд бэхлэх ёстой байтал хананд бэхэлсэн, халаалтын шугамын хамгаалалт хийгээгүй. Аймгийн Засаг даргын 2016 оны а/371 захирамжаар комиссын гишүүнд томилогдсон сургуулийн захирал, менежер нарыг барилга хүлээн авахад оролцуулаагүй, комиссын гишүүн бүрийн санал дүгнэлтийг гаргуулаагүй байна.*
- *Сургуулийн барилга, спорт заал /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ - Агааржуулагч, салхивчны тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийгдээгүйгээс огт ашиглаагүй болон гадна тохижилтын ажил дутуу хийгдсэн байхад 2015 оны 12-р сарын 20-ны өдрийн 45/2015 дугаар бүхий актаар улсын комисс ашиглалтад хүлээн авч, гүйцэтгэгч "Саруул цамхаг" ХХК-д 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр бүрэн олгосон тул аймгийн аудитын газраас албан шаардлага хүргүүлсэн байна.*

3.2 Векселиэр санхүүжилтээ авсан зарим төсөл, арга хэмжээний тухайд захиалагч зохих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, гүйцэтгэгчийн хариуцлагагүйгээс чанаргүй барилга, байгууламж баригдсан байна. *Тухайлбал,*

- *Цэцэрлэгийн барилга,150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 2 дугаар цэцэрлэг/: Гадна хашаа, хайсны ажил, тохижилт дутуу хийгдсэн, бүх анги танхимын цонхны амалгааны шавар унасан, дотор хананы шавар хагарсан, агааржуулах систем буруу хийгдсэн, дээврийн ус зайлуулах хоолой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явах зам дээр ус унахаар байрлуулсан.*
- *Сургуулийн спорт заалын барилга /Архангай, Өндөр-Улаан сум/: Дээврээс ус гоожсон, резинэн шал хуурсан, цонхны төмөр хаалтны бэхэлгээнүүдийн гагнаас салсан, ханын шавар зарим газарт хагаралт өгсөн байна.*
- *Цэцэрлэгийн барилгын засвар /Өвөрхангай, Арвайхээр сум, 4 дүгээр цэцэрлэг/: "Ган нэгдэл" ХХК-ийн гүйцэтгэсэн засварын ажилд цонхны тавцангийн амалгааны замаск ховхорч нурсан, дотор хана мөөгөнцөртөж харласан, чанар муутай будаг, эмульсээр будсанаас ховхорч хууларсан байна.*
- *Сэлэнгэ аймгийн Ерөө суманд баригдаж буй үйлчилгээний төвийн барилга: Ажлын үлдэгдэл санхүүжилтээр 8.3 сая төгрөгийн вексель бичигдэж, нийт гэрээний дүнд тусгагдсан 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан хэдий ч ажлын гүйцэтгэл хангалтгүй буюу цутгалтын ажил шаардлага хангаагүй, 2016 онд нэмж ажил хийгдээгүй гүйцэтгэл 44.7 хувьтай байна.*
- *Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/: "Карголэнд" ХХК-ний гүйцэтгэж буй тус барилга векселиэр 2016 онд 26.6 сая төгрөгийн санхүүжилт авч гэрээний үлдэгдэл 84.0 сая төгрөг байгаа боловч барилга угсралтын ажил үлдэгдэл санхүүжилтээр дуусах боломжгүй, барилгын зарим хэсэг нь тоногдсон, ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.*

3.3 Векселиэр санхүүжилт олгосон дараах барилгууд дээр өвлийн улиралд цутгалт хийж бетон хөлдсөн, чанаргүй баригдсан гэсэн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан байна. *Тухайлбал,*

- *1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн дотуур байрын барилга, 150 ор /Дархан-Уул, Шарын гол сум/ - Гүйцэтгэгч "Энигма констракшн" ХХК,*
- *0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/ - Гүйцэтгэгч "Талын монгол групп" ХХК.*

3.4 Дараах төсөл, арга хэмжээний тухайд улсын комисс хүлээн аваагүй, өмнөх гүйцэтгэгчийн хийгээгүй ажилд засварын тендер зарласан боловч улирлаас шалтгаалан барилга угсралтын ажил хийгдээгүй, санхүүжилтийг улсын төсөвт татуулахгүйн тулд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. *Тухайлбал,*

- *Архангай аймгийн Нийтийн номын сангийн барилгыг 2011 оноос "Донж Хацу" ХХК 486.0 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулах гэрээг БСШУСЯ-тай байгуулан гүйцэтгэсэн боловч чанарын шаардлага хангахгүй, ажил дутуу шалтгаанаар улсын комисс хүлээн аваагүй, чанар муутай баригдсанаас болж барилга одоог хүртэл ашиглагдаагүй байна.*
  *Ажлын гүйцэтгэл дутуу, байнгын ашиглалтад хүлээн аваагүй уг барилгад векселиэр 142.0 сая төгрөг олгохоор батлагдсан тул орон нутаг их засвар хийхээр шийдвэрлэж тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.*
  *Үүний үр дүнд их завсарын ажлын гүйцэтгэгчээр "Тамирын цахиур" ХХК шалгарч 128.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч худалдан авах ажиллагаа оройтсноос хүйтний улирал эхэлж гэрээт хугацаанд ажлыг бүрэн хийх боломжгүй болсон байна. Санхүүжилтийг БСШУСЯ-наас хүлээн авсан боловч гүйцэтгэгчид олголгүй орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.*
  *2017.03.20-ны байдлаар "Тамирын цахиур" ХХК гэрээт ажлаас дараах ажлыг гүйцэтгээгүй байна. Үүнд:*
  - *Дээврийн төмөр солих;*
  - *Гадна зогсоол, явган зам;*
  - *Шатны гишгүүр боржин чулуугаар солих;*
  - *Гадна фасад арын хэсэг;*

  *Нийтийн номын сангийн барилгыг улсын комисс хүлээн авах акт гараагүй байхад түүнд хийсэн их засварын ажлыг 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдөр улсын комисс хүлээн авч БАО-2016/18 актаар байнгын ашиглалтанд оруулсан байна. Хийгдээгүй ажлыг 2017 оны 05 дугаар сарын 10-ны дотор гүйцэтгэж дахин комисс ажиллуулж хүлээлгэн өгөхөөр хурлын тэмдэглэлд тусган гүйцэтгэгч болон захиалагчийн төлөөлөл зөвшөөрсөн байна.*

3.5 Векселиэр 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт баригдаж буй Сэргээн Засалт Үндэсний Төвийн нөхөн сэргээх сувиллын барилгын өргөтгөлийн ажлыг анх эхлүүлэхдээ Барилгын тухай хуулийн 18.1[10] дах заалт, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах журам, Төсвийн тухай хуулийн 29.4[11] дэх заалтыг зөрчсөнөөс улсын комисс ашиглалтад хүлээж аваагүй байна.

[10] Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ.
[11] Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

**Дүгнэлт:**

Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- УИХ-аас холбогдох шийдвэр, зөвшөөрөл гараагүй байхад векселийн үндсэн болон хүүгийн төлбөрийн зардлыг Засгийн газар, Сангийн яам шийдвэрлэж ирсэн нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

- Улсын төсвийн орлогыг бодитой төлөвлөж ирээгүйгээс векселийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна.

- Векселиэр төлбөрийг гүйцэтгэснээр төсвийн хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэж, явц удааширсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлснээрээ зохих үр дүнгээ өгсөн байна.

- Векселиэр санхүүжилт олгох тухай Засгийн газрын тогтоолын хавсралтуудад тусгагдсан хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн хувь бодит байдлаас зөрүүтэй байна.

- Векселиэр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

- Векселиэр санхүүжилтийг олгохдоо Төсвийн ерөнхийлөн захирагчдын дансаар дамжуулалгүй гүйцэтгэгчид шууд олгож ирсэн нь төлбөр, тооцооны зөрүү үүсэх шалтгаан болж байна.

- Засгийн газар нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийг зөрчсөн шийдвэр гаргасан нь төсвийн үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн чанар, ашиглалт хангалтгүй байна.

**Зөвлөмж:**

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**Монгол Улсын Ерөнхий сайдад:**

1. Векселиэр санхүүжилт олгох үйл ажиллагаанд хууль тогтоомж, холбогдох бусад шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

**Сангийн сайдад:**

1. Магадлашгүй ажлын актгүй, холбогдох баримт бүрдээгүй байхад векселиэр санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээнүүдэд магадлашгүй ажил хийгдсэн эсэхийг дахин нягталж, захиалагч, гүйцэтгэгчтэй тооцоо нийлэх, хийгдээгүй ажилд илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авах;
2. Санхүүжилт нь векселиэр төлөгдсөн, гүйцэтгэл дутуу, чанарын болон ашиглалтын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдтэй холбоотой, аудитын тайланд дурдсан зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч, захиалагч байгууллагуудад хяналт тавьж ажиллах;
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын төсвийн орлоготой уялдуулж, бодитой төлөвлөх замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

## Сангийн яамнаас ирүүлсэн санал

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2017.06.06 № 9/3385
танай 2017.05.31 -ны № 1025 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

"Засгийн газраас олгосон векселийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасны дагуу саналаа хүргүүлж байна. Үүнд:

**Тайлбар 1-ийг үзнэ үү.**

1. Тайлангийн холбогдох хэсэгт "Векселиэр санхүүжилтийг шийдвэрлсэнээр Монгол Улсын 2008-2015 оны төсвийн тухай хуульд тусгагдаж, тухайн төсвийн жилд бүрэн санхүүжигдээгүй, гэрээний үлдэгдэл төлбөр бүхий, гүйцэтгэгч компаниуд нь өөрийн хөрөнгө, банк, санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр ажлаа хийж дуусгасан боловч авч чадаагүй өр, төлбөрийг бүрэн барагдуулсан" гэж нэмж оруулах

**Тайлбар 2-ыг үзнэ үү.**

2. Тайлангийн "Бүлэг 2"-ийн дэд гарчиг буюу "Векселиэр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл бодит бус байна" гэсэн нь бодит бус гүйцэтгэлд вексель бичсэн мэт ойлгогдохоор байгаа тул дээрх хэсэг болон дүгнэлт хэсэгт "Векселиэр санхүүжсэн төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл УИХ-ын тогтоолоор заасан хувиас зөрүүтэй байна" гэж өөрчлөх;

**Тайлбар 3-ыг үзнэ үү.**

3. Тайлангийн төслийн 2.1-д заасан Өвөрхангай аймгийн Хужирт сумын цэцэрлэг, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын сургуулиас бусад ажил нь 2015-2016 онд ашиглалтанд орсон байна. Тухайлбал, Ахмадын сувиллын газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ ажил нь 2015 онд векселиэр санхүүжилт авч ашиглалтанд орсон, Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын ЦДАШ, дэд станцын барилга угсралтын ажилд вексель бичих үед Техникийн комисс ажилласан /бодит ажлын гүйцэтгэл 80 хувиас дээш/ байсан тул уг төсөл, арга хэмжээнүүдийг тухайн хэсгээс хасах, мөн ДЦС-4-өөс У-18 хүртэлх дулааны шугамын ажилд ямар нэгэн вексель бичигдээгүй, Хөгжлийн банкны санхүүжилтээр явж байсан тул хасах; /Векселиэр төлбөр гүйцэтгэх Засгийн газрын тогтоолыг салбарын яам буюу захиалагчийн ирүүлсэн санал, гүйцэтгэлийн мэдээллийн дагуу боловсруулж, батлуулсан бөгөөд эдгээр төслүүдийн захиалагчийн хяналтыг салбарын яам болон Барилгын хөгжлийн төв хийдэг тул дээрх байгууллагуудын ирүүлсэн гүйцэтгэлийн дагуу вексель олгосон болно/

**Тайлбар 4-ыг үзнэ үү.**

4. Тайлангийн төслийн 2.3-д заасан "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилгоор "Бэрэн" ХХК-иас 223 айлын орон сууцыг худалдан авах арга хэмжээний төлбөр болох 15.0 тэрбум төгрөгийн векселийг Засгийн газрын 298 дугаар тогтоолын дагуу бичиж, төлбөрийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид олгосон. Холбогдох тооцоо судалгааг Барилгын асуудал

6148

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан Засгийн газраас шийдвэр гаргасан тул энэ хэсгийг хасах;

**Тайлбар 5-ыг үзнэ үү.**

5. Тайлангийн төслийн 2.5 дах заалт нь векселийн төлбөр, тооцоотой холбоогүй, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй хөрөнгө оруулалтын ажлын төсөв зохиох, хянах, магадлан хийх үйл ажиллагаатай холбоотой байх тул хасах; /иргэний зориулалттай объектод 2%, үйлдвэрийн зориулалттай объектод 3%-иар тус тус тооцно./

**Тайлбар 6-г үзнэ үү.**

6. Тайлангийн төслийн 2.6-д заасан Батлан хамгаалахын сайдын багцад батлагдсан "Батлан хамгаалах их сургуулийн "Биеийн тамирын цогцолбор"-ын барилгыг 2013 оноос барьж эхэлсэн бөгөөд 2017 оны төсвийн тухай хуулиар 25.7 сая төгрөг батлагдсан. Тухайн барилгын төсөвт өртөг 6213.9 сая төгрөг бөгөөд төсөвт өртгийн задаргаанд тусгагдсан 108.9 сая төгрөгийн магадалшгүй ажил хийгдэж БХЯ-наас магадалшгүй ажлын актыг баталгаажуулж зардлын задаргааны хамт 2015 онд тус яаманд ирүүлсэн бөгөөд актыг үндэслэн магадалшгүй ажлын санхүүжилтийг олгосон байх тул уг ажлыг тухайн хэсгээс хасах;

**Тайлбар 7-г үзнэ үү.**

7. Мөн 2.6 хэсэгт заасан Батлан хамгаалахын сайдын багцад 2013 оноос "Говийн бүсийн сургалтын төв төсөл /Өмнөговь, Даланзадгад сум/" төсөл, арга хэмжээ нь үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд 2015 онд 1619.3 сая төгрөгийг векселиэр олгосон. Салбарын яамнаас ирүүлсэн уг гүйцэтгэлийн задаргаанд ямар нэгэн магадалшгүй ажлын зардал тусгагдаагүй "0" дүнтэй байсан тул уг ажлыг тухай хэсгээс хасах, мөн 2012 оноос "Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх /Улаанбаатар, Налайх дүүрэг/" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 онд 694.7 сая төгрөгийг векселиэр олгосон. Салбарын яамнаас ирүүлсэн 694.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн задаргаанд ямар нэгэн магадалшгүй ажлын зардал тусгагдаагүй "0" дүнтэй байсан тул уг ажлыг тухай хэсгээс хасах;

**Тайлбар 8-ыг үзнэ үү.**

8. Тайлангийн төслийн 2.7-д Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны захиалгаар баригдаж байгаа "Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Завхан, Улиастай сум, 3 дугаар сургууль/" төсөл, арга хэмжээ нь 2017 онд шилжин хэрэгжиж байгаа буюу гэрээ хэрэгжиж дуусаагүй байгаа тул жагсаалтаас хасах;

**Тайлбар 9-ийг үзнэ үү.**

9. Тайлангийн төслийн 2.8-д заасан техник хяналтын зардлыг вексель хүлээн авч мөнгөжүүлсэн гүйцэтгэгч байгууллагаас Эрчим хүчний яаманд төлөх ёстой бөгөөд уг тооцоо нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй тул хасах;

**Тайлбар 10-ыг үзнэ үү.**

10. Тайлангийн төслийн 2.9-ын гарчиг буюу "Засгийн газрын бодлого, шийдвэрийн тогтворгүй байдлаас төсвийн үр ашиггүй зардал бий болсон байна" гэдгийг "Макро эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж Засгийн газар төлбөрөө хугацаандаа барагдуулж чадаагүй болон валютын ханшийн зөрүү үүссэн байна." гэж өөрчлөх;

**Тайлбар 11-ийг үзнэ үү.**

11. Тайлангийн төслийн 3.6-д заасан Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга 60 км төсөл, арга хэмжээний барилгын ажлын гүйцэтгэлийн төлбөр болох 4.1 тэрбум төгрөгийн векселийг Засгийн газрын

2016 оны 195 дугаар тогтоолын дагуу бичиж гүйцэтгэгч аж ахуйн нэгжид олгосон бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2016 оны "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай 81 дүгээр тогтоол, Хөгжлийн банкны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 42, 219 дугаар тогтоолуудын дагуу Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүсэн өр авлагыг харилцан суутгах ажлыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон эцэслэн зохион байгуулсан тул векселийн үндсэн төлбөрийг төлөх боломжгүй болсон бөгөөд Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байсан төсөл, арга хэмжээнүүдийг 2017 оны Төсвийн тодотголоор Улсын төсвийн нэг бүрэлдэхүүн болгож, төсөл, арга хэмжээний жагсаалтад нэгтгэн батлсны дараа тус векселийн төлбөрийг төлсөн тул дээрх заалтыг хасах;

**Тайлбар 12-ыг үзнэ үү.**

12. Тайлангийн төслийн Ерөнхий мэдээллийн "Сангийн сайдын 2016 оны 22, 141 дүгээр тушаалуудад:" гэсэн хэсэгт УИХ болон Засгийн газрын холбогдох шийдвэр, зөвшөөрөлгүйгээр Сангийн сайд 2015 оны 22 болон 141 дүгээр тушаалаар вексель бичсэн гэсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 478 дугаар тогтоолын 5 дах заалтыг үндэслэн Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх төрлийн концессын гэрээг цуцалсны төлбөрийг векселиэр баталгаажуулсан тул тус хэсгийг хасах; */ЗГ-н 478 дугаар тогтоолын хуулбарыг хавсаргав/*

**Тайлбар 13-ыг үзнэ үү.**

13. Зөвлөмж 4.-т заасан "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг векселиэр санхүүжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгож, ТЕЗ-даас гүйцэтгэгчид тавих хяналтыг сайжруулах" гэснийг УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын (г)-д "улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдэл, "Барих-шилжүүлэх" концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн векселиэр баталгаажуулахгүй байх;" гэж заасан тул хасах.

Эдгээр саналуудыг тайланд тусгах дэмжиж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.НЯМАА

## Сангийн яамны саналд өгөх тайлбар:

| | |
|---|---|
| **Тайлбар 1** | Саналыг хүлээн авч, тайлангийн ерөнхий мэдээллийн хэсэгт зохих ёсоор найруулан тусгасан. |
| **Тайлбар 2** | Саналыг хүлээн авч найруулгыг өөрчилсөн болно. |
| **Тайлбар 3** | Зарим саналыг тусгаж, жагсаалтад өөрчлөлт оруулсан. |
| **Тайлбар 4** | Ирүүлсэн санал нь тайлангийн 2.3 дахь хэсэгт заасан худалдан авах ажиллагаанд баримтлах зарчмыг зөрчсөн асуудалтай хамаарахгүй байгаа тул тус саналыг хүлээж аваагүй болно. |
| **Тайлбар 5** | Саналыг харгалзан, найруулгыг өөрчлөн, тодруулсан болно. |
| **Тайлбар 6** | Саналыг харгалзан, холбогдох төсөл, арга хэмжээний нэрийг залруулсан болно. |
| **Тайлбар 7** | Төсвийн ерөнхийлөн захирагчид нь магадлашгүй ажлын зардлыг үндэслэлгүйгээр баталгаажуулж байсан нь аудитаар тогтоогдсон тул саналыг хүлээж аваагүй болно. |
| **Тайлбар 8** | Завхан аймгийн Улиастай сумын 3 дугаар сургуулийн барилга угсралтын ажил бүрэн хийгдэж байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж хүлээж авсныг аудитаар тогтоосон тул саналыг хүлээж аваагүй болно. |
| **Тайлбар 9** | Тухайн асуудал векселиэр санхүүжилт олгосон асуудалд хамаралгүй боловч төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчаас хүлээх үүрэг, хариуцлагад хамаарах тул ирүүлсэн саналыг хүлээж аваагүй болно. |
| **Тайлбар 10** | Төмөр зам барих, ашиглах, шилжүүлэх концессийн гэрээг байгуулах, цуцлах асуудал нь Засгийн газрын бодлого, шийдвэрээр хийгдсэн тул аудитын дүгнэлтийг өөрчлөх шаардлагагүй болно. |
| **Тайлбар 11** | Тайлбарыг үндэслэн ирүүлсэн саналыг хүлээн авсан болно. |
| **Тайлбар 12** | Тайлбарыг үндэслэн ирүүлсэн саналыг хүлээн авсан болно. |
| **Тайлбар 13** | Тайлбарыг үндэслэн ирүүлсэн саналыг хүлээн авсан болно. |

Хавсралт 1

## Засгийн газраас олгосон векселийн хураангуй

*/сая төгрөг/*

| № | Векселийн зориулалт | ЗГ-ын тогтоолын /дугаар, он/ | Векселиэр санхүүжүүлэх | | Векселиэр санхүүжүүлсэн | | Векселийн эргэн төлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төсөл, арга хэмжээ-ний тоо | Дүн | Бичигдсэн вексель /тоо/ | Дүн | Үндсэн төлбөр | Хүүгийн төлбөр | Нийт төлбөр | Он |
| **2015 он** | | | | | | | | | | |
| 1 | Нөөцийн махны урамшууллын үлдэгдэл төлбөр | 105/2015 | 4 | 4,500.0 | 4 | 4,500.0 | 4,500.0 | - | 4,500.0 | 2016 |
| 2 | Хөрөнгө оруулалтын вексель-2015 он | 282/2015 | 237 | 184,431.8 | 331 | 159,842.1 | 159,842.1 | 12,210.8 | 172,052.9 | 2016 |
| | **Дүн** | | **241** | **188,931.8** | **335** | **164,342.1** | **164,342.1** | **12,210.8** | **176,552.9** | |
| **2016 он** | | | | | | | | | | |
| 3 | Татварын буцаан олголт | - | 1 | 54,000.0 | 1 | 54,000.0 | 54,000.0 | - | 54,000.0 | |
| 4 | Төмөр замын вексель-ER | 478/2015 | 1 | 119,513.2 | 11 | 119,513.2 | 119,513.2 | 18,166.2 | 137,679.4 | 2017 |
| 5 | Төмөр замын вексель-ER Хүү | 284/2016 | 1 | 31,894.3 | 9 | 31,894.3 | 31,894.3 | - | 31,894.3 | 2016 |
| 6 | Төмөр замын вексель-QSC | 77/2016 | 1 | 183,608.6 | 18 | 183,608.6 | 183,608.6 | 27,357.8 | 210,966.4 | 2017 |
| 7 | Хөрөнгө оруулалтын вексель-2016 он | 72/2016 | 195 | 148,319.4 | 267 | 124,371.9 | 124,371.9 | 10,564.0 | 134,935.9 | 2016 |
| 8 | Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох /концесс/ | 72/2016 | 1 | 400.0 | 1 | 400.0 | 400.0 | 39.8 | 439.8 | 2016 |
| 9 | Мандал сум чиглэлийн 15.8 км авто зам /концесс/ | 72/2016 | 1 | 13,141.7 | - | - | - | - | - | - |
| 10 | Түрээсийн орон сууцны худалдан авалт | 298/2016 | 1 | 15,000.0 | 1 | 14,993.7 | 14,993.7 | 935.2 | 15,928.9 | 2016 |
| 11 | Ховдын Булган-Үенч-Ховдын 60 км авто зам | 195/2016 | 1 | 4,107.2 | 1 | 4,107.2 | 4,107.2 | 475.3 | 4,582.5 | 2017 |
| | **Дүн** | - | **203** | **569,984.4** | **309** | **532,888.9** | **532,888.9** | **57,538.3** | **590,427.2** | **-** |
| | **Нийт дүн** | - | **444** | **758,916.2** | **644** | **697,231.0** | **697,231.0** | **69,749.1** | **766,980.1** | **-** |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 09 өдөр Дугаар А/114 Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар, "Засгийн газраас олгосон векселийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг гуравдугаар, тус аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Даваанямм/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2017\0609GAG1.docx

070491

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны
6 дугаар сарын 09-ний өдрийн 6/114 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

УХА0122

## Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

/сая төгрөг/

| № | Төлбөр, зөрчил хариуцах | | Төлбөр, зөрчлийн товч утга | Акт, албан шаардлагын дугаар | Төлбөрийн актын дүн | Албан шаардлагын дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллага | Албан тушаал | | | | |
| **Засгийн газраас олгосон векселийн үр дүн /ҮАГ-ГАГ/2017/04-ГА/** | | | | | | |
| 1 | ЭМЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Гэрээний үнийн дүнгээс давуулж санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/28- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 20.1 | |
| 2 | ЭМЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Магадлашгүй ажлын актгүйгээр санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/29- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 1.7 | |
| 3 | БХЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Магадлашгүй ажлын актгүйгээр санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/30- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 14.6 | |
| 4 | БХЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Магадлашгүй ажлын актгүйгээр санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/31- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 10.9 | |
| 5 | БХЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Магадлашгүй ажлын актгүйгээр санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/32- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 6.2 | |
| 6 | БСШУСЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Гэрээний үнийн дүнгээс илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/33- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 19.4 | |
| 7 | БСШУСЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Гэрээний үнийн дүнгээс илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 01/34- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | 7.3 | |
| 8 | БСШУСЯ | Төрийн нарийн бичгийн дарга | Санхүүжилтийн тооцоог нийлж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх | 01/94- ҮАГ-ГАГ/2017/04-ГА | | 21.1 |
| ДҮН | | | | | 80.2 | 21.1 |